

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн
ашиглалт, үр өгөөж

АУДИТЫН КОД: ГСА-2023/25-6-ШТА-ГА

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор:
Б.Сарантуяа, Утас: 70543179
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр,
Утас: 70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дарханбат, Утас: 70543179
Цахим хаяг: darkhanbatb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

Тайланг бэлтгэсэн:

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Б.Сарантуяа

Аудитын менежер
Г.Наранбаяр

Ахлах аудитор
Б.Дарханбат

Аудитор
Г.Ариунцэцэг

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 70543179
дугаарын утсаар
харилцана уу.

ХАЯГ:

Сүмбэр сум 3-р баг,
Нутгийн удирдлагын
ордон, 213 тоот

2023 оны 08 дугаар сар

А.БНБУ-н Хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээс санхүүжсэн төслийн хөрөнгийн ашиглалт хангалтгүй байгаа нь төслийн үр дүнг бууруулж байна. 8

А.1. Зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ нь хөдөө, аж ахуйн салбарын хөгжлийн бодлоготой нийцсэн.8

А.2. БНБУ-ын Трактор, хөдөө аж ахуйн техник нийлүүлэх төслийн зээлийн хөрөнгийн ашиглалт хангалтгүй, зээлдэгч гэрээний үүргээ биелүүлээгүй байна.8

Б.Гадаадын тусламжаар олгосон малын тэжээл болон хүнсний тусламжийг зориулалтын дагуу зарцуулсан байна. 9

Б.1 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ нь салбарын бодлоготой уялдсан байна.9

Б.2 МААЭЗЭН төслөөс хэрэгжүүлсэн тэжээлийн тусламжийг тараах үйл ажиллагаанд аймгийн ЗДТГ, ХХААГ зэрэг мэргэжлийн байгууллагууд оролцоогүй байна.10

В.Зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад орон нутгийн хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхой зааж өгөөгүй нь орон нутагт хяналтын тогтолцоо үр нөлөөтэй хэрэгжихэд сөрөг нөлөө үзүүлж байна. 11

В.1 Зээл, тусламжийн хөрөнгийг олгох, хэрэгжүүлэх, ашиглахад тавих хяналт үр дүн муутай байна.11

В.2 Зээлийн хөрөнгийн ашиглалтын байдалд дүн шинжилгээ хийгээгүй, тусламжийн хөрөнгийг бүртгэж тайлагнаагүй байна.12

Дүгнэлт

Зөвлөмж

Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал

Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Тайлан баталгаажуулах тушаал

Тайлангийн хавсралтууд

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
БНБУ	Бүгд найрамдах Беларусь улс
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МААЭЗЭН	Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХААХХ	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэсэн.

Аудитын зорилт:

“Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Засгийн газрын шугамаар авсан зээлийг үр дүнтэй ашиглаж байгаа эсэх;
- Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн хөрөнгийн ашиглалт үр өгөөжтэй байгаа эсэх;
- Зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцоо үр нөлөөтэй эсэх;

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Монгол Улсын 2016-2022 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Өрийн удирдлагын тухай хууль
- Шилэн дансны тухай хууль (2014 он);
- “Алсын хараа” 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр
- Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам
- Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Говьсүмбэр аймагт 2016-2022 онд Хөдөө аж ахуйн салбарт зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл хөтөлбөр болон тэдгээрийг хэрэгжүүлсэн ТЕЗ, түүний харьяа байгууллагууд аймаг, сумдын ЗДТГ, ХХААГ, холбогдох бусад төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж

Аудитын арга зүй:

ахуй нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд аудит хийлээ. Төслийн төлөвлөлт, сонгон шалгаруулалттай холбоотой асуудлууд нь орон нутагт зохион байгуулагдаагүй нь аудитын хангалттай, зохистой нотлох баримт цуглуулах боломжгүй нөхцөл байдлыг үүсгэж байх тул асуудлын шинжилгээний А.1.2, Б.1.3 дахь асуултад **дүгнэлт өгөөгүй** ба Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2021 оны А/69 дүгээр тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ын 5 дугаар зүйлийн 5.3¹, 6 дугаар зүйлийн 6.1²-т тус тус заасны дагуу аудитын хязгаарлалтад оруулсан.

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-3:2020, MNS 6817-5:2020, MNS 6817-7:2020, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

**Аудит хийх багийн
бүрэлдэхүүн,
хугацаа:**

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дарханбат, аудитор Г.Ариунцэцэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын гүйцэтгэлийн үе шатыг 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөс эхлүүлж, тайланг Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан шалгагдагч байгууллага болон холбогдох эрх бүхий албан тушаалтанд 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдөр хүргүүлээ.

Хүндрэл бэрхшээл:

Орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудад хөдөө аж ахуйн салбарт зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл арга хэмжээний мэдээлэл хангалтгүй, хамтран ажилладаггүй, уялдаа холбоогүй байдал нь аудитад хүндрэл учруулж байсан.

Үндсэн мэдээлэл:

Говьсүмбэр аймагт 2016-2022 онд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Бүгд Найрамдах Беларусь Улсын хөгжлийн банкны дамжуулан зээлдүүлэх төслөөс 2 зээл, 2 тусламж 4 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн байна.

¹ Нотлох зүйл нь аудитын зорилгыг авч үзэх, илрүүлэлт болон дүгнэлтийг нотлон дэмжих хангалттай суурь олгоогүй. Ийм нотлох зүйлийг аудитор илрүүлэлт болон дүгнэлтийг дэмжихэд ашиглаж болохгүй.

² Хэрэв аудитын зорилго, хамрах хүрээ, арга зүй, цуглуулсан өгөгдөлд ямар нэгэн чухал хязгаарлалт байгаа бол уншигчид мэдэх хэрэгтэй ба ингэснээр тайлан дахь илрүүлэлт, дүгнэлт болон зөвлөмжийг үндэслэлтэй тайлбарлаж төөрөгдөл байхгүй болно.

Говьсүмбэр аймгийн Хөдөө аж ахуйн салбарт зээл, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжсэн
ТАХ-ний жагсаалт

Хүснэгт: №1

(мянган төгрөгөөр)

№	Санхүүжил- тийн эх үүсвэр	Төсөл хэрэгжс эн он	Төслийн нэр	Зориулалт	Мөнгөн дүн	Дууссан эсэх	Төрөл	Төлөгдс өн эсэх
1	Азийн хөгжлийн банк	2018.02. 14	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн Нэмэлт санхүүжилт	Ноос, ноолууран бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх	₮ 1,500,000.0	Тийм	Зээл	Тийм
2	Азийн хөгжлийн банк	2021.04. 22-27	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн Нэмэлт санхүүжилт	Өвөлжилт хүндэрсэн зарим аймгуудын малчдад хүнсний тусламжийн бараа нийлүүлэх	₮ 24,241.0	Тийм	Тусламж	-
3	Дэлхийн банк	2021.05. 04	Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл	Бусад аймгийн нутагт отроор явж байсан малчин өрхүүдэд нийт 120000 кг тэжээл нийлүүлэх	₮ 127,760.4	Тийм	Тусламж	-
4	БНБУ-н хөгжлийн банк	2021.09. 22	Трактор, хөдөө аж ахуйн техник нийлүүлэх төсөл	Трактор, хөдөө аж ахуйн техник нийлүүлэх	€ 22.05	Үгүй	Зээл	Үгүй

Хүснэгтээс харахад:

1. Чойр хайрхан ХХК-ийн Ноос, ноолууран бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх зориулалтаар авсан 1,500,000.0 мянган төгрөгийн төсөл хэрэгжиж, зээлийг хугацаанд нь эргэн төлсөн бол иргэн Н.Мөнхнарангийн Трактор, хөдөө аж ахуйн техник нийлүүлэх төслөөс авсан 22.05 мянган еврогийн зээл нь хугацаандаа эргэн төлөлт хийгдээгүй байна.
2. Азийн хөгжлийн банк болон Дэлхийн банкны тусламжаар 300 өрхөд 24,241.0 мянган төгрөгийн хүнсний тусламж, 4000 шуудай буюу 127,760.4 мянган төгрөгийн тэжээлийн тусламж үзүүлжээ.

Зураг товьёг

<i>№</i>	<i>Тайлбар</i>	<i>Хуудасны дугаар</i>
<i>Зураг 1</i>	БНБУ-ын зээлээр авсан трактор, тоног төхөөрөмж	9
<i>Зураг 2</i>	ХХАА, хөдөөгийн хөгжилт-Нэмэлт санхүүжилт төслийн зээлийн хөрөнгөөр санхүүжсэн ноосны үйлдвэр	9
<i>Зураг 3</i>	Хүнсний тусламж	11

Хүснэгтийн товьёг

<i>№</i>	<i>Тайлбар</i>	<i>Хуудасны дугаар</i>
<i>Хүснэгт 1</i>	Говьсүмбэр аймгийн Хөдөө аж ахуйн салбарт зээл, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжсэн ТАХ-ний жагсаалт	6
<i>Хүснэгт 2</i>	Бодлогын баримт бичгийн зорилтуудтай нийцсэн байдал	8
<i>Хүснэгт 3</i>	Бодлогын баримт бичгийн зорилтуудтай нийцсэн байдал	10
<i>Хүснэгт 4</i>	Малын зүй бус хорогдлын судалгаа	10
<i>Хүснэгт 5</i>	Малын тоо толгойн судалгаа	12

БҮЛЭГ А

БНБУ-ын Хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээс санхүүжсэн төслийн хөрөнгийн ашиглалт хангалтгүй байгаа нь төслийн үр дүнг бууруулж байна.

А.1. Зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ нь хөдөө, аж ахуйн салбарын хөгжлийн бодлоготой нийцсэн байна.

А.1.1. Азийн хөгжлийн банк болон БНБУ-ын санхүүжилтээр хэрэгжсэн төслийн зээлүүд нь МУ-ын урт, дунд, богино хугацааны зорилт, хөтөлбөрүүдийн дараах заалтуудтай нийцэж байна.

Бодлогын баримт бичигтэй нийцсэн байдал

Хүснэгт №2

№	Төслийн нэр	МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Монгол улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, тогтвортой хөдөө аж ахуй зорилт	Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого-Алсын хараа 2050
1	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн Нэмэлт санхүүжилт	2.51, 5.6.6.	4.2.2, 8.3.8, 8.3.9	4.2, 8.3
2	Трактор, хөдөө аж ахуйн техник нийлүүлэх төсөл	2.34, 2.45, 2.46	3.3.1	8.3

(Эх сурвалж: Аудитын ажлын баримт)

А.1.2. Төсөл, арга хэмжээний төлөвлөлттэй холбоотой баримт материал орон нутагт байхгүй тул аудитын хязгаарлалтад оруулсан.

А.2. БНБУ-ын Трактор, хөдөө аж ахуйн техник нийлүүлэх төслийн зээлийн хөрөнгийн ашиглалт хангалтгүй, зээлдэгч гэрээний үүргээ биелүүлээгүй байна.

А.2.1 Засгийн газраас түнш орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээл, уг зээлийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээний оролцогч талуудын хооронд үүсэх харилцааг Сангийн сайдын 2015 оны 196, 2021 оны 04 дүгээр тушаалын хавсралтаар тус тус батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-аар зохицуулж байна.

Говьсүмбэр аймгийн хөдөө аж ахуйн салбарт тайлант хугацаанд гадаад зээлийн эх үүсвэрээс санхүүжсэн 2 төслийн хөрөнгийн ашиглалт дараах байдалтай байна.


1. Азийн хөгжлийн банкны “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд Голомт банк болон “Чойр хайрхан” ХХК-тай байгуулсан гэрээний үүргийг тогтоосон хугацаанд нь биелүүлсэн байна.
2. Бүгд Найрамдах Беларусь улсын Хөгжлийн банкны дамжуулан зээлийн эх үүсвэрээс санхүүжсэн “Трактор, хөдөө аж ахуйн техник нийлүүлэх төсөл”-ийн хүрээнд иргэн Н.Мөнхнаран, Хөдөө аж ахуйг дэмжих сан хооронд “Трактор, хөдөө аж ахуйн техник худалдах, худалдан авах гэрээ” байгуулсан бөгөөд уг гэрээний 2.3³-г заасан үүргийг тогтоосон хугацаанд нь биелүүлээгүй байна.

А.2.2 “Трактор, хөдөө аж ахуйн техник нийлүүлэх төсөл”-ийн хадлангийн трактор, тоног төхөөрөмжийг 2021 онд хүлээн авсан боловч өнөөдрийг хүртэл зориулалтаар ашиглаагүй байгаа нь хөрөнгийг үр өгөөжтэй ашиглаагүйг харуулж байна.

Үүнд хадлан хадах талбайг урьдчилан сонгож тухайн сумын Засаг даргатай гэрээ байгуулаагүй, хадахаар төлөвлөсөн талбай гантай байсан зэрэг хүчин зүйлс нөлөөлжээ.

³ 2.3 Тоног төхөөрөмжийн үлдэгдэл төлбөрийг 3 жилийн хугацаанд тэнцүү хувааж төлөх ба тухайн жилийн тухайн өдрийн Монгол банкны ханшаар тооцож, энэ гэрээний 2.6-д заасан хуваариар төлнө.

Зураг №1



БНБУ-ын зээлээр авсан трактор, тоног төхөөрөмж

Харин Азийн хөгжлийн банкны “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд “Чойр хайрхан” ХХК нь зээлийн эх үүсвэрээс эргэлтийн хөрөнгө худалдан авч, самнах цехээ өргөтгөсөн ба үйл ажиллагаагаа хэвийн явуулж ноос, ноолуурыг угааж, самнан анхан шатны боловсруулалт хийн, эсгий үйлдвэрлэж байна.

Зураг: №2



ХХАА, хөдөөгийн хөгжилт-Нэмэлт санхүүжилт төслийн зээлийн
хөрөнгөөр санхүүжсэн ноосны үйлдвэр

БҮЛЭГ Б

Гадаадын тусламжаар олгосон малын тэжээл болон хүнсний
тусламжийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Б.1 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ нь салбарын бодлоготой уялдсан байна.

Б.1.1 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь урт, дунд, богино хугацааны бодлогыг дэмжиж байна.

Бодлогын баримт бичгийн зорилтуудтай нийцсэн байдал

Хүснэгт №3

№	Төслийн нэр	Зориулалт	МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Монгол улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, тогтвортой хөдөө аж ахуй зорилт	Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого- Алсын хараа 2050
1	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн Нэмэлт санхүүжилт	Өвөлжилт хүндэрсэн зарим аймгуудын малчдад хүнсний тусламжийн бараа нийлүүлэх	2.29.	8.3.15.	8.3

2	Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл	Бусад аймгийн нутагт отроор явж байсан малчин өрхүүдэд нийт 120000 кг тэжээл нийлүүлэх	2.34.	8.3.15.	8.3
---	---	---	-------	---------	-----

(Эх сурвалж: Аудитын ажлын баримт)

Б.1.2 Тусламж нь олон нийт, нийгмийн хэрэгцээ, шаардлагыг хангасан байна.

Хандивлагч орон, олон улсын байгууллагаас олгох буцалтгүй тусламжийг төлөвлөх, боловсруулах, хүлээн авах, бүртгэх, тэдгээрт оролцогч талуудын эрх үүргийг тодорхойлох, биелэлтэд хяналт тавих, үнэлэх, тайлагнахтай холбогдсон харилцааг Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Гадаадын зээл тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-аар зохицуулж байна.

Аймгийн хэмжээнд 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэн, аймаг дундын отрын бүс болох Малх отрын бүсэд 7 аймгийн 31 сумын 166 малчин өрхийн 187.5 мянга, отрын бүсээс гадна 103 өрхийн 78.8 мянган толгой мал орж ирснээр малын өвс, тэжээл хомсдож үнэ нэмэгдэж, малын зүй бус хорогдол их гарсан.

Жилийн эцсийн статистик мэдээгээр 39.7 мянган мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оноос 2.6 дахин өндөр үзүүлэлт бөгөөд хэрвээ малын тэжээлийн тусламж олгоогүй бол дээрх тоо нэмэгдэх эрсдэлтэй байжээ.

Малын зүй бус хорогдлын судалгаа

Хүснэгт: №4

Сум	2019	2020	2021	2022
Бүгд	5 666	14 663	39720	2514
Сүмбэр	4 461	12 128	30591	2212
Баянтал	866	1 910	3112	14
Шивээговь	339	625	6017	288

(төгрөгөөр)

(Эх сурвалж: Говьсүмбэр аймгийн Статистикийн эмхэтгэл-2022 он)

Мөн хүнсний тусламжид хамрагдах шаардлагатай 300 өрхийн судалгааг тухайн сумын багийн дарга нараар гаргуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/84 тоот захирамжаар томилогдсон ажлын хэсэг хүнсний тусламжийг хүлээн авах, тараах ажлыг зохион байгуулсан байна. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн МААЭЗЭН төслөөс Говьсүмбэр аймагт 4000 шуудай тэжээл хүлээн авч, олгож ажилласан хэдий ч ажлын хэсэг томилогүй байна.

Зураг: №3



Хүнсний тусламж тараасан байдал

Говьсүмбэр аймагт хэрэгжүүлсэн хүнс болон малын тэжээлийн тусламж нь цаг үеийн нөхцөл байдалд тохирсон, олон нийт, нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангасан байна.

Б.1.3 Тусламжийн хөрөнгийг сонгох, үнэлэх, эрэмбэлэхтэй холбоотой асуудлыг ХХААХҮЯ болон төслийн нэгж зохион байгуулсан бөгөөд орон нутагт хамааралгүй тул аудитын хязгаарлалтад оруулсан.

Б.2 МААЭЗЭН төслөөс хэрэгжүүлсэн тэжээлийн тусламжийг тараах үйл ажиллагаанд аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, ХХААГ зэрэг мэргэжлийн байгууллагууд оролцоогүй байна.

Б.2.1 Тайлант хугацаанд аймгийн хөдөө аж ахуйн салбарт гадаадын тусламжаар 2 төсөл хэрэгжсэн бөгөөд Азийн хөгжлийн банкны “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил, нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд 300 малчин өрхөд 24,241.0 мянган төгрөгийн хүнсний тусламж, Дэлхийн банкны “Мал аж ахуйн, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд 4000 ширхэг буюу 127,760.4 мянган төгрөгийн 120000 кг тэжээлийн тусламжийг тус тус хүлээн авчээ.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/84 дүгээр захирамжаар томилогдсон ажлын хэсэг 300 малчин өрхийн хүнсний тусламжийн барааг хүлээн авсан бөгөөд Сүмбэр суманд 180, Шивээговь суманд 70, Баянтал суманд 50 ширхэг хүнсний багцыг хүлээлгэн өгч сумдын Засаг даргын томилсон ажлын хэсэг 2021 оны 4 дүгээр сарын 23-наас 5 дугаар сарын 07-ны хооронд тараах ажлыг зохион байгуулсан.

Харин Дэлхийн банкны “Мал аж ахуйн, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд нийлүүлсэн 4000 ширхэг буюу 120тн тэжээлийг хүлээн авах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар томилоогүй, АЗДТГ-ын ХОХБТХ, аймгийн ХХААГ зэрэг салбарын бодлого хариуцсан хэлтэс, газрууд нь тэжээл хүлээн авах, тараах үйл ажиллагаанд оролцоогүй, хяналт тавьж ажиллаагүй байна.

Б.2.2 Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Гадаадын зээл тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 25 дугаар зүйлийн 25.3⁴-т заасны дагуу төслийн үр нөлөөний үнэлгээг хийлгэн, тайланг удирдлагын мэдээллийн системд оруулах зохицуулалттай байна.

Орон нутагт дээрх мэдээллийн системд нэвтрэх эрх олгогдоогүй байдгаас үйл ажиллагаа болон үнэлгээний тайлантай танилцаж дүгнэлт гаргах боломжгүй байсан болно.

Малын тэжээлийн болон хүнсний тусламж олгосны үр дүнд малын зүй бусаар хорогдох эрсдэлийг бууруулсан, малчин өрхөд учрах эдийн засгийн хохирлын хэмжээг багасгасан зэрэг үр дүнтэй байна.

Малын тоо, толгойн судалгаа

Хүснэгт: №5

(төгрөгөөр)				
Сум	2019	2020	2021	2022
Бүгд	452004	450997	432196	464294
Сүмбэр	325928	322066	317859	339830
Баянтал	70684	69705	65327	72035
Шивээговь	55392	59226	49010	52429

(Эх сурвалж: Говьсүмбэр аймгийн Статистикийн эмхэтгэл-2022 он)

БҮЛЭГ В

Зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад орон нутгийн хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхой зааж өгөөгүй нь орон нутагт хяналтын тогтолцоо үр нөлөөтэй хэрэгжихэд сөрөг нөлөө үзүүлж байна.

В.1 Зээл, тусламжийн хөрөнгийг олгох, хэрэгжүүлэх, ашиглахад тавих хяналт үр дүн муутай байна.

В.1.1 Зээл тусламжаар хэрэгжсэн, хэрэгжиж байгаа төслүүдийн шилэн дансанд оруулсан мэдээллийг тулгахад 2021 онд хэрэгжсэн МААЭЗЭН төслийн мэдээллийг бүрэн гүйцэт тайлагнасан байна.

Харин ХААХХ-ийн нэмэлт санхүүжилтээр хэрэгжсэн төслүүд болох 2018 оны “Ноос ноолууран бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх” төсөл болон 2021 оны “Өвөлжилт

⁴ 25.3. Үр нөлөөний үнэлгээ хийлгэх ажлыг төсөл хэрэгжүүлэгч байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал эрхэлсэн нэгж хариуцан зохион байгуулах бөгөөд үнэлгээний тайланг Удирдлагын мэдээллийн системд оруулна.

хүндэрсэн аймгуудын малчдад хүнсний тусламжийн бараа нийлүүлэх” төсөл, БНБУ-ын хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн “Трактор, хөдөө аж ахуйн техник нийлүүлэх” төслүүдийн мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 3.2.6, 6.4.8, 6.5.2, 7.1 дүгээр заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

В.1.2 Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн Нэмэлт санхүүжилт”-ээр хэрэгжсэн “Өвөлжилт хүндэрсэн зарим аймгуудын малчдад хүнсний тусламжийн бараа нийлүүлэх” төслийн хүрээнд аймгийн ЗДТГ болон ХХААГ-аас хүнсний тусламжийн бараа олголтод хяналт тавьж ажилласан байна.

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн МААЭЗЭН төслөөс Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум 4000 шуудай тэжээл хүлээн авч Шивээговь суманд 495 шуудай, Баянтал суманд 450 шуудай, Сүмбэр суманд 2995 шуудай, Цом сүргийн үржлийн төвд 60 шуудай тэжээлийг тус тус олгосон байна.

Аймгийн Засаг даргын шийдвэрээр тэжээл хүлээн авах, тараах ажлын хэсгийг томилоогүйгээс АЗДТГ-ын ХОХБТХ болон ХХААГ зэрэг салбарын газар, хэлтсүүд тэжээлийг хүлээн авах, тараах үйл ажиллагаанд оролцоогүй нь хяналт тавих ажил орхигдох шалтгаан болсон байна.

Үүнд орон нутгийн мэргэжлийн байгууллагын чиг үүргийг Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Гадаадын зээл тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-д тусгаагүй нь нөлөөлж байна.

Цаашид хөдөө аж ахуйн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж төслүүдийн талаар мэдээллийн сан үүсгэх, хэрэгжилтийн байдалд хяналт тавьж, үр дүнг мэдээлж байх шаардлагатай байна.

В.2 Зээлийн хөрөнгийн ашиглалтын байдалд дүн шинжилгээ хийгээгүй, тусламжийн хөрөнгийг бүртгэж тайлагнаагүй байна.

В.2.1 БНБУ-ын Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн Трактор, хөдөө аж ахуйн техник хэрэгслийн зээлийн хөрөнгийн ашиглалтын байдалд дүн шинжилгээ хийгээгүй, үр дүнг тооцоогүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 10 дугаар зүйлийн 10.1⁵-т заасныг зөрчсөн байна.

Төслийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхгүй байх нь тухайн төслийн хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулах, хяналт тавихад сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байна.

В.2.2 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнг зохих хууль тогтоомжийн дагуу бүртгэж, тайлагнаагүй байна. Тухайлбал:

1. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн “Өвөлжилт хүндэрсэн зарим аймгуудын малчдад хүнсний тусламжийн бараа нийлүүлэх” төслийн 24,241.0 мянга, Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн МААЭЗЭН төслийн 127,760.4 мянган төгрөгийн тусламжийн тэжээлийг аймаг, сумын ЗДТГ нь санхүүгийн тайлан бүртгэлд тусгаж, тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4⁶, 14 дүгээр зүйлийн 14.4.2⁷, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4⁸-т заасныг тус тус зөрчсөн

⁵ 10.1 Төсөл, арга хэмжээний суурь нөхцөл байдал, хэрэгжилтийн явц, үйл ажиллагааны зорилт, шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл, үр дүнг үнэлэх, тулгарч буй асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх, үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор төсөл, арга хэмжээний үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

⁶ 5.1.4 Үнэн зөв байх

⁷ 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;

⁸ 6.3.4.төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх.

бөгөөд тусламжийн хөрөнгийг бүртгэхгүй байх нь залилан болон түүнтэй холбоотой эрсдэл үүсэх, тусламж зорилтот хэрэглэгчиддээ очихгүй байх, санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх зэрэг сөрөг үр нөлөөтэй байна.

Аудитаар нийт 152.0 сая төгрөгийн 2 зөрчил илрүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 152.0 сая төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Ерөнхий дүгнэлт: *Зээлийн хөрөнгөөр санхүүжсэн төслийн хөрөнгийн ашиглалт хангалтгүй, хяналтын тогтолцоонд орон нутгийн хэрэгжүүлэх чиг үүргийг тусгайлан заагаагүй нь хяналт, төслийн үр дүнд сөрөгөөр нөлөөлж байна.*

Бүлэг-А: БНБУ-н Хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээс санхүүжсэн төслийн хөрөнгийн ашиглалт хангалтгүй байгаа нь төслийн үр дүнг бууруулж байна.

Бүлэг-Б: Гадаадын тусламжаар олгосон малын тэжээл болон хүнсний тусламжийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Бүлэг-В: Зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад орон нутгийн байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхой зааж өгөөгүй нь орон нутагт хяналтын тогтолцоо үр нөлөөтэй хэрэгжихэд сөрөг нөлөө үзүүлж байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн ЗДТГ-н ХОХБТХ-д:

1. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн үр дүнд бий болсон хөрөнгийг аймаг, сумдын ЗДТГ-т бүртгүүлж байх

Аймгийн ХХААГ-т:

1. Хөдөө аж ахуйн салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн талаар мэдээллийн сан үүсгэх, хэрэгжилтийн байдалд хяналт тавих

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАКАРТ УЛАМЖЛАХ САНАЛ

1. БНБУ-н Хөгжлийн банкны “Трактор, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж нийлүүлэх” төслийн хүрээнд Хөдөө аж ахуйг дэмжих сангаас дамжуулан зээлсэн 22.0 мянган еврогийн зээлийн эргэн төлөлт хийгдээгүй байгаа тул Хөдөө аж ахуйг дэмжих санд зээлийг эргэн төлүүлэх албан шаардлага хүргүүлэх
2. “Гадаадын зээл тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-д Орон нутгийн салбарын /мэргэжлийн/ болон бодлого хэрэгжүүлэгч байгууллагуудын чиг үүргийг тодорхой тусгуулах

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР
42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Найрамдал хотхон, Утас: 7054 3261,
И-мэйл: hhaagggsa@yahoo.com

᠒᠐᠒3.08.15 № ᠐᠑/12᠑
танай ᠒᠐᠒3.08.15 ны № 1᠑8 -т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжийн дагуу гүйцэтгэсэн “Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцав.

Тайланд тусгах саналгүй болно.

ДАРГА



Э.ТҮВШИНЗАЯА

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Шалгагдагч байгууллагаас аудитын тайлантай холбоотой санал ирээгүй тул тайланг
Дарга, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулав.



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2023 оны 08 сарын 17 өдөр

Дугаар А/19

Чойр

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу "Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж"-д хийсэн Гүйцэтгэлийн аудитын тайлан, зөрчлийн жагсаалтийг хавсралтаар баталсугай.

2. "Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж"-д хийсэн Гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга, ХХААГ-т тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитын тайланд дурдагдсан зөрчлийг арилган, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2024 оны 05 дугаар сарын 25-ны дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн ХХААГ-ын дарга Э.Түвшинзаяад зөвлөсүгэй.

4. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор Б.Дарханбат, аудитор Г.Ариунцэцэг нарт даалгасугай.



Б.САРАНТУЯА

D:\DOTOOD AJIL\TUSHAAL.doc

008010054

Аудитын нэр: Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүтэлийн мөнгө

Аудитын код: ГСА-2023/25-6-ШТА-ГА

Байгууллагын нэр: Аймэг, сумын ЗДТГ, ХХААГ

(Мянган төгрөгөөр)

№	Аудитын чиглэл өсүүлт	Алдаа, зөрчлийн төв утга	Зөрчсөн заалт	Мөнгөн дүн /сая.төгрөг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгалдагч байгууллагын санал, тайлбар	Гаргасан шийдэл
А	1	2	3	4	5	6	7
1	В.1.2.3.Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл, арга хэмжээнд эрх бүхий байгууллагууд хяналт тавьж байна уу?	Дэлхийн банкны "Мал аж ахуйн, адийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх" төслийн хүрээнд нийлүүлсэн 4000 ширхэг буюу 120тн тэжээлийг хүлээн авах ахуйн хэсгийг аймгийн засаг даргын захирамжаар томилоогүй, АЗДТГ-ын ХОХБТХ-ийн ХХААГ зэрэг салбарын бодлого хэрэгжүүлсэн хэлтэс, газрууд нь тэжээл хүлээн авах, тараах үйл ажиллагаанд оролцоогүй, хяналт тавьж ажиллаагүй байна.	Төслийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.7	-	Зөвлөмж	Хүлээн зөвшөөрсөн	
2	В.2.2.Зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнг зохиох хууль, тогтоомжийн дагуу бүртгэж тайлагнаж байна уу?	Адийн хэсгийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн "Өвөлжилт хүчдэрсэн зарим аймгуудын малчдад хүнсний тусламжийн барааг нийлүүлэх төслийн 24,241.0 мянга, дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн МААЗЗЭН төслийн 127,760.4 мянган төгрөгийн тусламжийн тэжээлийг аймэг, сумын ЗДТГ нь санхүүгийн тайлан бүртгэлд тусгаж, тайлагнаагүй байна	Нэгтгэл бодох бүтэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, Төслийн тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 6.3.4	152,001.40	Зөвлөмж	Хүлээн зөвшөөрсөн	
Нийт				152,001.4			

Балтгасан:

Тангилцаж зөвшөөрсөн:

Ахлах аудитор

Б.Дарханбат

Аудитор:

Г.Ариунцац

Амхан шатанда хянасан:

Г.Наранбаяр

Аудитын менежер

Б.Сарантуяа

Хоёр дахь шатанд хянасан:

Дарга, Тарүүлэх аудитор

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга

Г.Хонгор

Аймгийн ХХААГ-ын дарга

Э.Түвшинсаяа